



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/217

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 384,922,222.24 (гурван зуун наян дөрвөн сая есөн зуун хорин хоёр мянга хоёр зуун хорин хоёр төгрөг хорин дөрвөн мөнгө) төгрөгийн 7 тээврийн хэрэгсэл, Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 32,781,000.00 (гучин хоёр сая долоон зуун наян нэгэн мянга) төгрөгийн 1 тээврийн хэрэгсэл, Ерөнхий боловсролын “Шинэ Монгол Харүмафүжи” сургуулиас хандиваар ирсэн 20,000,000 (хорин сая) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслүүдийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2. Хавсралтад заасан тээврийн хэрэгслийг бүртгэн авч, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар (П.Эрхэмбулган)-т, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (О.Ганбат)-т, Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэс (Д.Бат-Эрдэнэ)-т, Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т, Сонгинохайрхан дүүргийн Отгон долоон бурхан Өрхийн эрүүл мэндийн төв (Д.Баярбат)-д, Сонгинохайрхан дүүргийн “Эхэн босго” Өрхийн эрүүл мэндийн төв (Ж.Энхжаргал)-д, Сонгинохайрхан дүүргийн “Одонт манал” Өрхийн эрүүл мэндийн төв (Л.Оюунчимэг)-д, Сонгинохайрхан дүүргийн “Батцэцэн” Өрхийн эрүүл мэндийн төв (С.Энхномин)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110200982

